

Баян-Олгий аймгаас Улаанбаатар руу явахад бэрхшээлтэй байна. Нислэгийн тийз болон автобусны билет олдохгүй, шинэ оюутнуудад хүндрэл үүсчээ.

Хэдхэн хоногийн олно Арабын орнуудаас ирсэн хэсэг жуулчид Улаанбаатар руу нисэхээр дугаар бичүүлсэн хүмүүсээс нэг мянган ам.доллараар тийзийг нь худалдан авсан аж. Харин онцгой ажил хэрэг гарсан иргэд нислэгийн тийз олж ядан бухимдсаар байна. Аймгийн тээврийн газрын дарга К.Сейфуллин энэ тухай тайлбарлахдаа, "Автобусаар явахаар хүмүүс долдугаар сарын 20-ноос литр бичүүлсэн. Бичүүлсэн хүний тоо 2500 хүрснээр билет дууссан. Одор тутам хоёр компанийн автобусууд саадгүй явсаар байна. Нэмэлт автобус ажиллуулах арга хэмжээ авч байна. Ямар ч гэсэн билет худалдан авсан зорчигчдыг энэ сарын 20-25-нд багтаан нийслэлд хүргэнэ. Харин зорчигч бүр гар тээштэйгээ 20 кг ачаагаа орон нутгийн цагаар 15 цагаас олно авч ирээд явахад бэлэн болох, жолооч нар тээврийн хэрэгслээ бүрэн бүтэн байлгах, тогтоосон тоо хэмжээнээс илүү ачаа болон хүн тээвэрлэхгүй байх ёстой" гэлээ.